



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 04 сарын 02 өдөр

Дугаар 100

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.3, 6.4.4, 6.4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Эдийн засаг, техникийн хамтын ажиллагааны тухай” Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу БНХАУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Хилийн боомтын дэд бүтэц” төслийн хүрээнд хийгдэх ажлын бэлтгэл хангах зайлшгүй шаардлагыг харгалзан Гаалийн ерөнхий газрын харьяа Өмнөговь аймгийн Гашуунсухайт дахь Гаалийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 242,834,509.00 (хоёр зуун дөчин хоёр сая найман зуун гучин дөрвөн мянга таван зуун есөн) төгрөгийн балансын үнэ, 117,547,001.21 (нэг зуун арван долоон сая таван зуун дөчин долоон мянга нэг төгрөг хорин нэгэн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий нэгдүгээр хавсралтад заасан үл хөдлөх хөрөнгө, Гаалийн ерөнхий газрын харьяа Сэлэнгэ аймаг дахь Гаалийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 4,042,936,276.34 (дөрвөн тэрбум дөчин хоёр сая есөн зуун гучин зургаан мянга хоёр зуун далан зургаан төгрөг гучин дөрвөн мөнгө) төгрөгийн балансын үнэ, 432,820,842.68 (дөрвөн зуун гучин хоёр сая найман зуун хорин мянга найман зуун дөчин хоёр төгрөг жаран найман мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хоёрдугаар хавсралтад заасан үл хөдлөх хөрөнгийг буулгаж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Наранцогт, Гаалийн ерөнхий газрын дарга Б.Асралт нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг буулгаж, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Үл хөдлөх хөрөнгийг буулгах, газар (чөлөөлөгдөх талбай)-ыг албан ажлын зориулалтаас өөрөөр ашиглахгүй байх;

2.4. Үл хөдлөх хөрөнгийг буулгаж, ашиглаж болох эд зүйлийг ялган тоолж, худалдан борлуулах;

2.5. Авсан арга хэмжээний биелэлтийг 2019 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

0000157

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 4 дүгээр барын ...-ны өдрийн
... дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

Гаалийн ерөнхий газрын харьяа Өмнөговь аймаг дахь Гашуунсухайт дахь Гаалийн газрын
үндсэн хөрөнгөд бүртгэлтэй акалж, данснаас хасах барилга, байгууламж

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Тоо сэжмэх	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Бүгд үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
1	Уурын зуух Дизелийн барилга грааж	2006.12.01	1	46,887,358.00	46,887,358.00	11,146,442.22	35,740,915.78
2	Уурын зуухны халаалтын шугам ШНЦ	2012.12.31	1	24,815,000.00	24,815,000.00	7,154,991.60	17,660,008.40
3	Шинэ халаалтын тогоо	2015.12.29	2	38,412,877.50	76,825,755.00	48,656,311.50	28,169,443.50
4	Сүлжээний насос	2015.12.29	2	1,213,500.00	2,427,000.00	1,537,100.00	889,900.00
5	Тэлэлтийн сав	2015.12.29	2	1,568,000.00	3,136,000.00	1,986,133.46	1,149,866.54
6	Цэвэр усны насос	2015.12.29	2	752,000.00	1,504,000.00	952,533.46	551,466.54
7	Ялтсан халаалтын дулаан солилцуур	2015.12.29	2	3,600,000.00	7,200,000.00	2,280,000.00	4,920,000.00
8	Гашуунсухайт боомтын сантехникийн ажил	2007.12.31	1	28,580,480.00	28,580,480.00	14,857,312.87	13,723,167.13
9	Нүүрсний хашаа	2008.12.25	1	1,520,000.00	1,520,000.00	1,507,305.60	12,694.40
10	Ажлын байр	1998.01.01	1	2,520,050.00	2,520,050.00	836,508.20	1,683,541.80
11	Гадна дулааны шугам ШНЦ	2006.12.01	1	31,400,059.00	31,400,059.00	16,275,705.20	15,124,353.80
12	Гадна бохир цэвэр усны шугам ШНЦ	2006.12.01	1	9,242,466.00	9,242,466.00	5,432,516.00	3,809,950.00
13	Бохирын цооног /цэвэрлэх байгууламж	2006.12.01	1	6,776,341.00	6,776,341.00	4,924,141.10	1,852,199.90
	Нийт дүн		18		242,834,509.00 (хоёр зуун дөчин хоёр сая найман зуун гучин дөрвөн мянга таван зуун есөн)	117,547,001.21 (нэг зуун арван долоон сая таван зуун дөчин долоон мянга нэг төгрөг хорин нэгэн мөнгө)	125,287,507.79 (нэг зуун хорин таван сая хоёр зуун наян долоон мянга таван зуун долоон төгрөг далан есөн мөнгө)

6098169 1118262882

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн
... дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

Гаалийн ерөнхий газрын харьяа Сэлэнгэ аймгийн Алтанбулаг суман дахь
Гаалийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй акталж, данснаас хасах барилга, байгууламж

6098169 4118262983

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	О Т Х	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Бүгд үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
1	Төхөөрөмжийн удирдлагын байр	2015.10.14	1	45,125,472.00	45,125,472.00	4,073,827.29	41,051,644.71
2	АБ Уурын зуухны барилга	2002.09.23	1	315,369,954.19	315,369,954.19	76,059,670.84	239,310,283.35
3	Уурын зуухын тогоо	2015.12.23	2	34,112,618.00	68,225,236.00	13,645,047.24	54,580,188.76
4	Уурын зуухын тоног төхөөрөмж	2015.12.23	1	21,164,000.00	21,164,000.00	9,086,999.76	12,077,000.24
5	Усан даралтын цамхаг	2002.10.01	1	46,502,734.00	46,502,734.00	31,993,880.62	14,508,853.38
6	Авто пүү	2002.10.01	1	47,119,171.50	47,119,171.50	47,119,171.50	0.00
7	Авто шалгагчийн ба пүүлэгчийн байр	2002.09.29	2	3,407,585.50	6,815,171.00	6,815,171.00	0.00
8	Авто шалгагчийн ба пүүлэгчийн байр	2002.09.28	2	3,407,585.50	6,815,171.00	6,815,171.00	0.00
9	Гар тэргэнцэрийн байр	2002.10.01	2	3,737,781.50	7,475,563.00	7,475,563.00	0.00
10	Эрэлч нохойн байр	2002.10.01	1	7,102,328.00	7,102,328.00	7,102,328.00	0.00
11	Гүний худгийн барилга	2002.09.23	1	396,900.00	396,900.00	238,140.10	158,759.90
12	Эрэлч нохойн угсармал байр	2010.12.30	2	2,298,457.00	4,596,914.00	2,451,687.37	2,145,226.63
13	Цахилгаан хангамж холбоо	2002-10-02	1	155,542,800.00	155,542,800.00	100,666,928.44	54,875,871.56
14	Гадна цэвэр бохир усны шугам	2002-10-02	1	148,411,426.00	148,411,426.00	115,902,256.52	32,509,169.48
15	Эрэлч нохойн сургалтын талбай	2002-10-02	1	500,000.00	500,000.00	374,999.76	125,000.24
16	Гааль 100 жил дурсгалын багана	2012-05-30	1	5,000,000.00	5,000,000.00	3,000,000.24	1,999,999.76
17	Эрүүл ахуй халдвар судлалын станц	2002.09.23	1	126,425,600.00	126,425,600.00	0.00	126,425,600.00
18	Цахилгааны дэд станц	2002.09.23	1	50,606,415.00	50,606,415.00	0.00	50,606,415.00
19	Харуулын байр	2002.10.01	1	6,972,500.00	6,972,500.00	0.00	6,972,500.00
20	А.Т.Х Шалгах тавцан, саравч	2002.09.23	1	483,807,661.00	483,807,661.00	0.00	483,807,661.00
21	Суудлын машины саравч	2002.09.24	1	33,140,466.00	33,140,466.00	0.00	33,140,466.00
22	Ус зайлуулах байгууламж	2002-10-02	1	56,179,200.00	56,179,200.00	0.00	56,179,200.00
23	Галын резервуар 200м3	2002-10-02	1	95,810,117.00	95,810,117.00	0.00	95,810,117.00
24	Гадна дулааны шугам	2002-10-02	1	201,705,000.00	201,705,000.00	0.00	201,705,000.00

25	Гадна хашаа	2002-10-02	1	130,587,868.00	130,587,868.00	0.00	130,587,868.00
26	Зүлэгжүүлэлт	2002-10-02	1	88,044,000.00	88,044,000.00	0.00	88,044,000.00
27	Түр гарц, зам талбай	2002-10-02	1	200,662,827.00	200,662,827.00	0.00	200,662,827.00
28	Өндөржилт зам талбай	2002-10-02	1	1,627,031,781.65	1,627,031,781.65	0.00	1,627,031,781.65
29	Бохир усны цооног	2002-10-02	1	55,800,000.00	55,800,000.00	0.00	55,800,000.00
	Нийт дүн		34		4,042,936,276.34 (дөрвөн тэрбум дөчин хоёр сая есөн зуун гучин зургаан мянга хоёр зуун далан зургаан төгрөг гучин дөрвөн мөнгө)	432,820,842.68 (дөрвөн зуун гучин хоёр сая найман зуун хорин мянга найман зуун дөчин хоёр төгрөг жаран найман мөнгө)	3,610,115,433.66 (гурван тэрбум зургаан зуун арван сая нэг зуун арван таван мянга дөрвөн зуун гучин гурван төгрөг жаран зургаан мөнгө)